



PARTNERS LLC

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Уур амьсгалын өөрчлөлтийг даван туулах тухай анхдагч хуулийн
төслийн үр нөлөөг үнэлэх

Улаанбаатар хот
2025 он

АГУУЛГА

СУДАЛГААНЫ ТАЙЛАН.....	0
НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ.....	2
ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ.....	3
ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ СОНГОСОН БАЙДАЛ.....	5
ДӨРӨВ. УРЬДЧИЛАН СОНГОСОН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ ...	6
4.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:	6
4.2. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:	9
4.3. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:	12
4.4. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:.....	14
ТАВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГӨХ.....	17
5.1. Үр дүнг баримтжуулах.....	17
5.2. Үнэлгээний шалгуурын дүн шинжилгээ.....	17
5.3. ЗӨВЛӨМЖ.....	17

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Уур амьсгалын өөрчлөлтийг даван туулах тухай хуулийн төслийн зүйл, заалтад тодорхой шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцох, давхардал, хийдэл, зөрчил байгаа эсэхийг тогтоох, арилгах, хуулийн зүйл, заалтыг ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулах, улмаар хуулийн төслийн чанарыг сайжруулахад тус үнэлгээний ажлын зорилго оршино.

Уур амьсгалын өөрчлөлтийг даван туулах тухай хуулийн төслийн /цаашид “хуулийн төсөл” гэх/ үр нөлөөг үнэлэх ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх тооцох аргачлал”¹-д заасны дагуу дараах үе шаттайгаар гүйцэтгэлээ.

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох;
3. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхдээ үндсэн 5 шалгуур үзүүлэлтийн хүрээнд тэдгээрийг шалгах хэрэгслийг ашиглан хуулийн төслийн зохицуулалт нь уг хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлага, хуулийн төслийн зорилгод нийцсэн эсэх, зорилгод хүрэх боломжтой байдлаар тусгагдсан эсэх, хуулийн төсөл нь ойлгомжтой, зүйл, заалт нь өөр хоорондоо болон бусад хүчин төгөлдөр хууль тогтоомжтой нийцсэн эсэхийг үнэлж, төсвөөс гарах зардлын тооцоог хийж, тэдгээрийн үр дүнд үндэслэн анхаарах, өөрчлөх шаардлагатай зохицуулалтын талаар хуулийн төсөл боловсруулагчид зөвлөмж өгсөн.

¹ Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан.

ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

Тус үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан, аргачлалд дурдсан 6 шалгуур үзүүлэлтээс 5 шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал
2. Практикт хэрэгжих боломж
3. Ойлгомжтой байдал
4. Харилцан уялдаа
6. Зардал

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зорилтоос сонгон авсан зорилт нь 1.Үзэл баримтлалд тусгасан хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл шаардлагад нийцсэн эсэх, 2. Хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төслийн зорилтуудад хүрэхэд чиглэгдэж байгаа эсэхийг тогтооно. Өөрөөр хэлбэл, Хуулийн төслийн зорилт нь хуулийн зохицуулалтаар хүрэх боломжтой байна уу гэдгийг үнэлэхээр сонголоо.

“Практикт хэрэгжих боломж” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн хуулийн төслийн зохицуулалтыг дагаж мөрдөх буюу хэрэгжүүлэх боломжтой эсэхийг, тухайлбал, хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээд байгаа эсэх, тэдгээр этгээдэд тухайн хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж, бололцоо (санхүү, хүний нөөц зэрэг) байгаа эсэхийг шалгаж тооцохоор сонголоо.

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийг хуулийн төсөл нь ойлгомжтой, логик дараалалтай томъёологдсон эсэх, хуулийн төсөл, түүний зохицуулалтыг нэг мөр ойлгож хэрэгжүүлэх боломжтой эсэхийг шалгах үүднээс холбогдох этгээдээс санал авах, хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянах байдлаар үнэлгээг хийхээр сонголоо.

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг бүхэлд нь Монгол улсын Үндсэн хууль, Монгол улсын Олон улсын гэрээ, холбогдох бусад хуульд нийцсэн эсэхийг “Хууль тогтоомжийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-д заасан асуултад хариулах байдлаар үр нөлөөний үнэлгээг хийхээр сонгов.

“Зардал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалт иргэн, аж ахуйн нэгж, байгууллага болон улсын төсөвт ачаалал, хөнгөлөлтийг үүсгэх, төрийн байгууллагад хуулийн төслийг хэрэгжүүлэхэд үүсэх зардал, уг зардлын улмаас үүсэх үр дагавар зэргийг холбогдох аргачлалын хүрээнд тооцохоор сонгов.

Хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардлын тооцоог тусгайлан хийх тул цаг хугацаа, нөөцийн хэмнэлт хийх үүднээс “зардал тооцох” шалгуур үзүүлэлтийг зардлын тооцооны тайланд тусгасан болно.

Хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардлын тооцоог тусгайлан хийх тул

цаг хугацаа, нөөцийн хэмнэлт хийх үүднээс “зардал тооцох” шалгуур үзүүлэлтийг зардлын тооцооны тайланд тусгасан болно.

ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ СОНГОСОН БАЙДАЛ

“Зорилгод хүрэх байдал” Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлага, хуулийн төслийн зорилгод хуулийн төслийн зохицуулалт нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх үүднээс хуулийн төслийн үзэл баримтлалтай танилцаж, хуулийн төслийн зорилго болон зорилгод хүрэхэд чиглэгдсэн, мөн түүнийг тодорхой илэрхийлж чадахуйц арга хэмжээ, зохицуулалтыг сонгож авав. Хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төслийн зорилгыг хангахад чиглэсэн эсэхийг үнэлэх үүднээс хуулийн төслийн зорилгод хүрэхэд чиглэсэн хуулийн төслийн Хоёрдугаар бүлэг буюу 6, 7, 8, 9, 10, 11, 12 15, 19, 20, 21, 22 дугаар зүйлүүдийг тус тус сонгон авсан болно.

“Практикт хэрэгжих боломж” Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд аргачлалд тусгасан хуулийн төслийн хэрэгжих боломжийг үнэлэх замаар хуулийн төслийг бүхэлд нь сонгон авлаа.

“Ойлгомжтой байдал” Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөл нь боловсруулалтын хувьд Хууль тогтоомжийн тухай хуулийн Дөрөвдүгээр бүлэгт болон Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг, түүнчлэн хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдүүд хуулийг нэг мөр ойлгож хэрэглэх, хэрэгжүүлэх боломжтой байдлаар боловсруулагдсан эсэхийг шалгахын тулд хуулийн төслийг бүхэлд нь сонгон авлаа. /Хуулийн төсөл 29 зүйлтэй/

“Харилцан уялдаа” Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд аргачлалд тусгасан хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх жишиг асуултуудад хариулах замаар уялдаа холбоог шалгахын тулд хуулийн төслийг бүхэлд нь сонгон авлаа. /Хуулийн төсөл 29 зүйлтэй/

ДӨРӨВ. УРЬДЧИЛАН СОНГОСОН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Өмнөх үе шатуудад хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгийг тогтоосон бөгөөд урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирсон аргачлалд тодорхойлогдсон дараах шалгах хэрэгслүүд байна.

Хүснэгт 1. Шалгах хэрэгслүүд

Д/д	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	хуулийн төслийн Хоёрдугаар бүлэг буюу 6, 7, 8, 9, 10, 11, 12 15, 19, 20, 21, 22 дугаар зүйлүүдийг тус тус сонгон авсан болно.	Хуулийн төслийн дэвшүүлсэн зорилтыг хангах эсэхэд дүн шинжилгээ хийх
2	Практикт хэрэгжих боломж	Хуулийн төсөл бүхэлдээ	Хуулийн төслийг тусгай зөвшөөрөл эзэмшигч, төрийн байгууллага, төрийн бус байгууллагуудад этгээдүүдтэй нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулах, хуулийн төсөлд ирүүлсэн саналуудад дүн шинжилгээ хийх
3	Ойлгомжтой байдал	Хуулийн төсөл бүхэлдээ	Хууль тогтоомжийн тухай хуулийн 23, 28, 29, 30 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах
5	Харилцан уялдаа	Хуулийн төсөл	Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах

Дээрх шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг дараах байдлаар үнэллээ.

4.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Зорилгод хүрэх байдал гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс сонгосон хэм хэмжээг тухайн хуулийн төслийн зорилтыг хангахад чиглэгдсэн эсэхийг судлах замаар үнэлгээг тогтооно. Хуулийн төслийн зорилгыг дараах байдлаар тодорхойлсон байна. Энэ хуулийн зорилго нь:

Уур амьсгалын өөрчлөлтийг даван туулах тухай хуулийн зорилго нь уур амьсгалын өөрчлөлтийг тэсвэрлэх даван туулах, нөлөөлөл, эрсдэл, эмзэг байдал, гарз хохирол, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, экосистемийн тэнцвэр, байгаль орчин, нийгэм, эдийн засгийн тогтвортой байдлыг хангахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино. Энэхүү хуулийн төсөл нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой уялдуулан уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох зорилгуудыг хэрэгжүүлэхэд чиглэсэн зохицуулалтыг агуулж байна.

Хуулийн төслийн 2-р бүлэгт уур амьсгалын өөрчлөлтийг даван туулах, түүнд дасан зохицох чадварыг сайжруулах талаар төрийн байгууллагуудын хэрэгжүүлэх чиг үүрэг, бүрэн эрхийг тусгаж өгсөн нь нэгдсэн бодлого зохицуулалтыг хэрэгжүүлэх институтын тогтолцоог бий болгосон байна. Үүнд:

- 1. Улсын Их Хурал:** төрөөс уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг даван туулах, дасан зохицох, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, шингээлтийг нэмэгдүүлэх талаар баримтлах бодлогын баримт бичгийг батлах, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, тухайн жилийн төсвийн төсөлд энэ хуулийг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийг тусган батлах, хяналт тавихаартусгасан. Энэхүү зохицуулалт нь уур амьсгалын бодлогыг улсын хэмжээний хөгжлийн бодлогын нэгдсэн төлөвлөгөөний салшгүй хэсэг болгон баталгаажуулж, хэрэгжилтийн явцыг тогтмол хянах, үнэлэх боломжийг бүрдүүлж байна. Ингэснээр уур амьсгалын өөрчлөлтийн зорилтыг хөгжлийн бодлого, төсвийн төлөвлөлттэй уялдуулан хэрэгжүүлж, бодлогын үр дүнг тогтвортой хэмжиж, шаардлагатай үед сайжруулалт хийх нөхцөлийг хангах боломж бүрдэнэ.
- 2. Засгийн газар:** Засгийн газар нь Үндэсний зорилт болон Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үндэсний төлөвлөгөө, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбоотой баримт бичгийг батлах, хэрэгжилтийг хангах, хяналт тавих, ногоон санхүүжилтийн хөшүүрэг, хэрэгслийг энэ хууль, холбогдох бусад хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэх, ногоон санхүүжилт татах зорилгоор хоёр талт болон олон талт гэрээ, хэлэлцээрийг энэ хууль, холбогдох бусад хууль тогтоомжид заасны дагуу байгуулах, олон улсын ногоон санхүүжилт олгодог байгууллагад Засгийн газрыг төлөөлөх байгууллагыг томилох, чадавхыг бэхжүүлэх, олон талын оролцоог нэмэгдүүлэх, уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хороог байгуулж, дүрмийг батлах зэрэг шийдвэрийг гаргахаар тусгасан байна. Энэ нь Засгийн газрын түвшинд уур амьсгалын бодлогын хэрэгжилтийг төвлөрсөн байдлаар удирдах, хэрэгжилтийн явцыг хянах механизмыг бүрдүүлж, салбар дундын бодлогын уялдааг хангах зохицуулалт болсон байна. Энэ нь уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг зорилтыг тогтвортой хэрэгжүүлэх, хэрэгжүүлэх чиг үүргийг тодорхойлох, бодлогын нэгдмэл байдлыг хангах боломжийг бүрдүүлсэн байна.
- 3. Уур амьсгалын үндэсний хороо:** уур амьсгалын өөрчлөлтийг даван туулах, дасан зохицох, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, шингээлтийг нэмэгдүүлэх карбон зах зээлийн асуудлаар хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, хууль тогтоомжид өөрчлөлт оруулах асуудлаар салбар дундын нэгдсэн санал, зөвлөмж гаргах, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг холбогдох шийдвэрт тусгуулах санал гаргах, Үндэсний зорилт, Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үндэсний төлөвлөгөө, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбоотой баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах, тусгах санал гаргаж, хүргүүлэх, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл, эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээ хийх, дасан зохицох, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, шингээлтийг нэмэгдүүлэх эдийн засгийн салбар, бүс нутгийг тодорхойлох, Монгол Улс уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой Олон улсын гэрээний дагуу тайлагнахаар үүрэг хүлээсэн тайланг хэлэлцэн баталгаажуулах зэргээр салбар дундын уялдаа холбоог хангаж, уур амьсгалын асуудлыг хөгжлийн бодлого, төлөвлөлтөд үр дүнтэй тусгах үүрэгтэй.

Тус хороо нь шинжлэх ухаан, техник, эрдэм шинжилгээний байгууллагуудаас мэргэжлийн дэмжлэг авах замаар уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг арга хэмжээг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр төлөвлөх боломжийг бүрдүүлдэг. Ингэснээр бодлогын шийдвэрүүд илүү үндэслэлтэй болж, хэрэгжилтийн үр дүн сайжрах нөхцөл бүрддэг бөгөөд энэ нь уур амьсгалын бодлогыг үр ашигтай хэрэгжүүлэхэд чухал үүрэгтэй юм.

4. **Төрийн захиргааны төв байгууллагууд:** Төрийн захиргааны төв байгууллагууд нь өөрсдийн салбарын хүрээнд уур амьсгалын өөрчлөлтийн бодлогыг хэрэгжүүлэх, хүлэмжийн хийн ялгарал бууруулах, дасан зохицох арга хэмжээнүүдийг батлах, хяналт-шинжилгээ хийх үүрэгтэй. Энэ бүтэц нь салбар дундын нэгдсэн зохицуулалт, хамтын ажиллагааг хангаж, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг хариу арга хэмжээг салбар тус бүрд оновчтой төлөвлөж, хэрэгжүүлэх нөхцөл бүрдүүлж байна.
5. **Орон нутгийн удирдлагууд:** Аймаг, нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг дарга нар тухайн орон нутгийн онцлогт тохирсон уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төлөвлөгөөг батлах, хэрэгжүүлэх үүрэгтэй. Энэхүү зохицуулалт нь уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй байдлыг орон нутгийн түвшинд хангах, хөрөнгө, нөөцийг илүү оновчтой хуваарилахад дэмжлэг болно.
6. **Хүлэмжийн хийн бүртгэл хариуцсан байгууллага:** Тус байгууллага нь Үндэсний зорилтын биелэлтийг хянахад шаардлагатай өгөгдөл, мэдээг цуглуулж бүртгэлжүүлэх, хүлэмжийн хийн үндэсний тооллогын өгөгдөл, мэдээллийг хадгалах, тогтмол шинэчлэх, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, шингээх төсөл, хөтөлбөр, карбон кредитийн бүртгэлийн системийг холбогдох журмын дагуу удирдаж, нээлттэй мэдээлэх, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, шингээх төсөл, хөтөлбөр, карбон кредит бүртгэхэд шаардагдах мэдээлэл, баримт бичгийг төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэгч талаас гаргуулах, улс хооронд шилжүүлж, арилжаалагдсан баримт бичгийг үндэслэн хүлэмжийн хийн тооллогод харгалзах тохиргоо, өөрчлөлтийг хийн үндэсний болон олон улсын түвшинд ил тод тайлагнаж давхар тоололтоос сэргийлэх, Үндэсний зорилтын гүйцэтгэл, хүлэмжийн хийн үндэсний тайланг тогтсон хугацаанд, олон улсын арга зүй, холбогдох журмын дагуу боловсруулж, тайлагнах зэрэг эрх, үүрэгтэй байна. Энэхүү зохицуулалтын хүрээнд Монгол Улсад хүлэмжийн хийн бүртгэлийг хийдэг албан ёсны байгууллагын эрх зүйн байдлыг хуульчилсан байна.

Эдгээр зохицуулалтууд нь уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг авч хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийг сайжруулах, төрийн байгууллагуудын чиг үүргийг тодорхойлж, салбар дундын зохицуулалт, мэдээлэл солилцоог хөнгөвчлөх, бодлогын хэрэгжилтийг нэгдсэн байдлаар хянах, үнэлэх боломжийг бүрдүүлж байна.

Хуулийн төсөлд тодорхойлсон Үндэсний зорилт, тайлагнал, нотлох үйл ажиллагааны журам батлах заалт (9.2.6-д Уур амьсгалын өөрчлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Үндэсний зорилтын хэрэгжилтийг тооцох, тайлагнах, баталгаажуулах журмыг эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батлах, хэрэгжилтийг хангах, 9.3.5-д тухайн салбарын уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг байдал болон эрсдэлийн үнэлгээг боловсруулж, хэрэгжүүлэх, 20.1-д Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага уур амьсгалын өөрчлөлтийг хянаж, үнэлж, ирээдүйн төлөв байдал, чиг хандлагыг тодорхойлохоор тус тус заасан нь хуулийн зорилгод хүрэх явцыг хэмжих, хянахад чухал ач холбогдолтой зохицуулалт болсон

байна.

Төсөлд уур амьсгалын өөрчлөлтийг даван туулах, түүнд дасан зохицох зорилтуудыг тодорхойлж, эдгээр зорилгод хүрэхэд шаардлагатай зохицуулалтын механизмуудыг багтаасан. Тухайлбал, хуулийн төслийн 15.1.Хүлэмжийн хийн тэнцвэрийг хангах зорилтыг нийгэм, эдийн засгийн дунд болон урт хугацааны хөгжлийн бодлого, стратегид тусган хэрэгжүүлэхээр заасан нь

уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг бодлогын суурь механизмыг бий болгож байна.

Хуулийн төсөлд дасан зохицох төлөвлөгөөний талаар тусгаж, орон нутгийн түвшинд хэрхэн хэрэгжүүлэх талаар нарийвчлан зохицуулсан байна. (11 дугаар зүйл). Тухайлбал, Засаг дарга нар нутгийн хэмжээнд дасан зохицох төлөвлөгөө баталж, хэрэгжүүлэх үүрэгтэй бөгөөд энэ нь орон нутгийн түвшинд уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй байдлыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн нь хуулийн төслийн зорилготой нийцэж байна.

Уур амьсгалын өөрчлөлтийн мэдээллийн санг бүрдүүлэх, тайлан мэдээлэлд суурилсан хяналт-шинжилгээ хийх заалтууд (21 дүгээр зүйл) нь зорилгод хүрэхэд хэрэгжилтийн явцыг дэмжсэн зохицуулалт болсон байна. Тухалбал, хүлэмжийн хийн ялгарал болон дасан зохицох арга хэмжээний үр дүнг мэдээллийн санд бүртгэхээр заасан нь хуулийн хэрэгжилтийн түвшнийг мэдээлэлд үндэслэн хянах боломжийг олгож байна.

Хуулийн төсөлд хөгжлийн зорилтуудтай уялдуулан хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, шингээлтийг нэмэгдүүлэх карбоны зах зээлийн харилцааг тусгасан байна. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үүссэн карбон кредитийг тухайн төсөл ххөтөлбөр хэрэгжүүлэгч нь өмчлөх ба уг кредитийг арилжих зөвшөөрлийг эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгохоор заасан. Карбон кредитийн бүртгэл, худалдаа, арилжаа, шилжүүлэгийн харилцааг хуулийн төслийн 19 дүгээр зүйлд заасан. Тус зохицуулалтын хүрээнд карбон кредитийн бүртгэл, худалдаа, арилжаа, шилжүүлэг нь стандарт, шаардлагыг хангасан оролцогчдын хувьд нээлттэй бөгөөд хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үйл ажиллагаанаас үүссэн карбон кредитийг хоёр талын болон олон талын арилжаанд оролцогч талууд баталгаажуулснаар шилжих боломжтой болно.

Хуулийн төслийн 22 дугаар зүйлд заасан "Ногоон санхүүжилтийн эх үүсвэрийн" тухай зохицуулалт нь уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, түүнд дасан зохицох зорилтыг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг тодорхойлох зорилготой зохицуулалт болсон байна. Энэхүү санхүүжилт нь уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, урьдчилан сэргийлэх, даван туулах, хор хохирлыг арилгах, хүлэмжийн хийн ялгарлыг багасгах, бууруулах, ялгах, шингээх, хадгалах болон карбоны зах зээлийг хөгжүүлэхэд чиглэсэн төсөл, хөтөлбөр, үйл ажиллагааг санхүүжүүлэхэд дэмжлэг үзүүлэх бөгөөд Монгол Улсын урт хугацааны зорилгод нийцсэн санхүүжилтийн нэгдсэн механизм бий болгох нөхцөлийг бүрдүүлж байна.

4.2. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд Уур амьсгалын өөрчлөлтийг даван туулах тухай хуулийн төсөл Хууль тогтоомжийн тухай хуулийн 26, 28, 29, 30 дугаар зүйл,

Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан хангасан эсэхэд хариулт өгөх замаар төслийг бүхэлд нь шалгалаа.

Хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.1 дэх заалтад хамаарах анхдагч хуулийн төсөл байна. Хуулийн төсөл нь 8 бүлэг, 26 зүйлтэй.

Хуулийн төслийн бүх зүйл, заалтууд нь хамаарах этгээдүүдэд ойлгомжтой, нэг мөр ойлгогдохуйц байдлаар томъёологдсон байна. Хуулийн төслийг боловсруулагчийн зүгээс Хууль тогтоомжийн тухай хууль, “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-ыг баримтлан боловсруулсан байна.

Тухайн хуулийн төсөлд хамаарах этгээдүүдээс санал авч, хуулийн төсөл, түүний зохицуулалтыг нэг мөр ойлгож, хэрэгжүүлэх боломжтой байгаа эсэхийг дүгнэхэд шаардлагатай мэдээлэл дутуу байна. Түүнчлэн, тухайн хуулийн төсөлд төрийн байгууллагад шинэ бүтэц бий болгох, чиг үүрэг нэмэх зэрэг зохицуулалт тусгасан байна.

Лүснэгт 2. Эх бичвэрийн агуулгад тавих шаардлага

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага		
дд	Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт	Хуулийн төслийн зохицуулалтад үнэлгээ хийсэн байдал
1.	29.1.1. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой уялдсан байх;	Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, нэгдэн орсон олон улсын гэрээнд нийцсэн байна.
2.	29.1.2.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;	29.1.2-г заасны дагуу хуулийн төсөл нь нийгмийн харилцааны шаардлагатай бүх асуудлыг иж бүрнээр хамруулсан, зохицуулалт тус бүр нь тодорхой байдлаар тусгагдсан байна.
3.	29.1.3.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;	Хуулийн төсөлд тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгаагүй.
4.	29.1.4.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;	Тус хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгаагүй.
5.	29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;	Төслийн зүйл, хэсэг, заалт хоорондоо зөрчилгүй байна.

6.	29.1.6.хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;	29.1.6-д заасны дагуу хуулийн төсөл нь хэмжээгүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжих заалтыг агуулаагүй, тогтвортой, тодорхой үргэлжлэх зохицуулалтыг багтаасан байна. Энэ нь хуулийн үр нөлөө, тогтвортой байдлыг хангаж байгаа учраас шалгуурыг хангаж байна.
7.	29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах,энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;	Хуулийн төсөлд тухайн төслийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, зохицуулалтыг өөр хуультай давхардуулахгүй, тодорхой байдлаар томъёолсон байна. Мөн хуулийн төсөлд зарим зүйл, заалтуудын хүрээнд олон улсын гэрээ, үндэсний хууль тогтоомжуудыг эш татаж, эх сурвалжийг тодорхой заасан байна. Тухайлбал, хүлэмжийн хийн тооллого хийх болон карбоны зах зээлийн зохицуулалтуудыг олон улсын болон үндэсний холбогдох хуулийн зохицуулалттай уялдуулан эш татсан бөгөөд хуулийн нэр, албан ёсны эх сурвалжийг тодорхой дурдсан байна.
8.	29.1.8.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох зарчим, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журмыг тусгасан байх.	<p>Хуулийн төсөлд Монгол Улсын уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх, дасан зохицох чиглэлээр зохицуулах хүрээг тогтоож, хуулийн үйлчлэх хүрээг тодорхойлсон байна. Энэхүү хүрээнд хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, карбоны зах зээлийг хөгжүүлэх, эрсдэлийн үнэлгээ, санхүүжилтийн механизмыг тодорхойлох зэрэг нийгмийн харилцааны үндсэн чиглэлийг хамруулсан байна.</p> <p>Хуулийн төсөлд эрх зүйн харилцаанд оролцогчид буюу төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд, мөн тухайн хуулийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд оролцогч иргэдийн эрх, үүргийг тодорхойлсон байна.</p> <p>Хуулийн төсөлд уур амьсгалын өөрчлөлтийг даван туулах, дасан зохицох үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд удирдлага болгох үндсэн зарчим, харгалзан үзэх нөхцөл байдлыг тусгасан байна. Үүнд, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг бууруулах, байгаль орчныг хамгаалах зэрэг зарчмууд тусгагдсан байх бөгөөд эдгээрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай нөхцөл байдлыг харгалзан үзэх шаардлагыг тодорхойлсон байна.</p> <p>Тус хуулиар нийтийн эрх зүйн этгээд буюу төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг, эрх хэмжээ, эдгээрийг хэрэгжүүлэхэд</p>

	<p>процесс, журмыг тодорхойлсон байна. Тухайлбал, хүлэмжийн хийн тооллого хийх, эрсдэлийн үнэлгээг зохион байгуулах, Үндэсний бүртгэл хөтлөх зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр заасан байна.</p> <p>Тухайн хууль нь зохицуулах нийгмийн харилцаа болон холбогдох эрх зүйн харилцаанд оролцогчдын эрх, үүргийг тодорхой тусгаж, удирдлага болгох зарчим, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, хэрэгжилтийг тодорхой тусгах шаардлагыг хангасан байна.</p>
--	---

Хүснэгт 3. Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага

30 дугаар зүйл. Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага		
1.	30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх;	Хуулийн төслийн нэр томъёог хууль тогтоомжид нийцүүлэн Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуультай нийцүүлэн хэрэглэсэн байна. Жишээлбэл, “уур амьсгалын өөрчлөлт”, “хүлэмжийн хий”, “карбон кредит” зэрэг нэр томъёог тодорхойлсон байна.
2.	30.1.2.нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй	Хуульд хэрэглэсэн нэр томъёо бүрийн тодорхойлолтыг өгснөөр энэ шаардлагыг хангаж, хоёрдмол утга үүсгэхээс зайлсхийсэн байна. Нэр томъёо бүрийг нэг утгатай, ойлгомжтой байдлаар тусгасан байна.
3.	30.1.3.үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;	Хууль зүйн найруулгыг Монгол хэлний дүрэмд нийцүүлж, товч бөгөөд тодорхой, ойлгоход хялбар байдлаар бичсэн байна.
4.	30.1.4.хүч оруулсан нэр томъёо хэрэглэхгүй байх;	Хүч оруулсан үг ашиглагдаагүй.
5.	30.1.5.жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх	Хуулийн төслийн нэр томъёо болон зохицуулалтыг ганц тоон дээр хэрэглэх шаардлагыг хангасан байна.

4.3. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

“Практикт хэрэгжих боломж” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн хуулийн төслийн зохицуулалтыг дагаж мөрдөх буюу хэрэгжүүлэх боломжтой эсэхийг, тухайлбал, хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээд байгаа эсэх, тэдгээр этгээдэд тухайн хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж, бололцоо (санхүү, хүний нөөц зэрэг) байгаа эсэхийг шалгаж тооцно.

Дараах үндэслэлийн дагуу тус хуулийн төсөл практикт хэрэгжих боломжтой гэж дүгнэлээ.

1. Хуулийг хэрэгжүүлэх субъект тодорхой: Хуулийн төслийн хэрэгжилтийг хангах үндсэн субъектүүд нь Засгийн газар, Уур амьсгалын Үндэсний хороо, Хорооны ажлын алба, холбогдох яамд, төрийн захиргааны байгууллага, хүлэмжийн хийн бүртгэл хариуцсан байгууллага болно. Үүнээс гадна, уур амьсгалын өөрчлөлтийн талаар салбар дундын хамтын ажиллагаа, шийдвэр гаргах түвшний нэгдсэн бодлогын хэрэгжилтийг хангасан зохицуулалтууд тусгагдсан байгаа нь чухал ач холбогдолтой.
2. Хүний нөөцийн чадавхыг тусгасан: Хуулийн төслийн хэрэгжилтэд шаардагдах хүний нөөцийг хуулиар тодорхойлсон буюу Уур амьсгалын Үндэсний хороо орон тооны ажлын албатай байхаар тусгасан байна. Энэ албаны ажилтнууд нь уур амьсгалын бодлого, зохицуулалтын асуудлаар мэргэшсэн, шинжлэх ухааны үндэслэл бүхий мэдээлэл боловсруулах, судалгаа хийх чадавхтай байх шаардлагатай.
3. Санхүүгийн эх үүсвэр ба төсөв зохицуулагдсан: Хуулийн хэрэгжилтийн санхүүгийн эх үүсвэрийг улсын төсвөөс гаргахыг хуулийн төсөлд заасан. Төсөв нь ажлын албаны зардал, судалгаа шинжилгээний ажил, мэдээллийн нэгдсэн сангийн үйл ажиллагаа, тайлан гаргах, мэргэжилтнүүдийг сургах, шаардлагатай техник хэрэгсэл худалдан авахад зарцуулагдана.

Мэдээллийн нэгдсэн систем ба тайлагнал: Хуулийн төслийн дагуу мэдээллийн нэгдсэн сантай байна. Энэхүү мэдээллийн сан нь уур амьсгалын өөрчлөлтийн талаархи үндэсний түвшний мэдээллийг төвлөрүүлж, олон нийтийн хүртээмжтэй байдлыг хангах үүрэгтэй. Хорооны ажлын алба тайлан, мэдээлэл гаргах үйл ажиллагааг удирдан зохион байгуулна. Үндэсний зорилтын хэрэгжилтийн тайланг холбогдох эрх бүхий этгээдэд тайлагнаж, мөн олон улсын гэрээнд заасан шаардлагын дагуу мэдээлэл хүргүүлнэ.

Хуулийн төслийн практикт хэрэгжих боломж өндөр бөгөөд хэрэгжүүлэх субъектуудын бүтэц, үүрэг хариуцлага, хүний нөөцийн чадавх, санхүүжилтийн тогтолцоо, мэдээллийн систем, хяналт, тайлагналын механизм зэрэг гол зохицуулалтуудыг нарийвчлан тодорхойлсон байна.

4.4. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

“Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ын 4.10-г заасан уялдаа холбоог шалгах хэрэгсэлд дурдагдсан шалгуурыг хангасан эсэхийг дараах байдлаар үнэллээ. “Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг аргачлалд тусгасан хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх стандарт асуултуудад хариулах замаар уялдаа холбоог шалгахын тулд хуулийн төслийг бүхэлд нь авч үзэхээр тооцлоо.

Хүснэгт 4. Харилцан уялдаа шалгуур үзүүлэлт

Д/д	Асуулт	Хариулт	Хуулийн төслийн зохицуулалтад үнэлгээ хийсэн байдал
1	Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх	Тийм	Хуулийн төслийн зохицуулалт нь үзэл баримтлалд тусгагдсан зорилт, болон хуулийн төсөлд тусгасан зорилттой нийцэж байна.
2	Хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх	Тийм	Хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн болохыг тодорхой зааж өгсөн байна. Хуулийн төслийн 2.1-д "Уур амьсгалын өөрчлөлтийг даван туулах хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжоос бүрдэнэ. " гэж заасан байна.
3	Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх;	Тийм	Энэхүү шаардлагыг хангасан байна.
4	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх;	Тийм	Энэхүү шаардлагыг хангасан байна.
5	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх;	Үгүй	Энэхүү шаардлагыг хангасан байна.
6	хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой	Тийм	Хуулийн төслийг хэрэгжүүлэгч субъектүүдийн эрх үүргийг ялган тодорхойлсон байна.

	тусгасан эсэх;		
7	хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх;	Үгүй	Хуулийн төсөлд уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой үндсэн зохицуулалтуудыг тодорхой тусгаж өгсөн
8	хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх;	Тийм	Хуулийн төсөлд төрийн байгууллагуудын чиг үүрэг тодорхой заагдсан бөгөөд өөр хоорондоо давхардал байхгүй байна.
9	төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх;	Тийм	<p>Шинжлэх ухааны байгууллага, судалгааны хүрээлэнгүүд болон мэргэжлийн холбоодоор уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, мэдээлэл цуглуулах, үнэлгээ хийх, техникийн зөвлөмж боловсруулах үүргийг гүйцэтгүүлэх боломжтой.</p> <p>Мэргэжлийн холбоод, зөвлөх компаниудыг бодлого, стратеги боловсруулах, төсөл хэрэгжүүлэхэд татан оролцуулах боломжтой.</p> <p>Олон нийтэд мэдээлэл түгээх, сургалт зохион байгуулах, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх чиг үүргийг төрийн бус байгууллага, ТББ-д шилжүүлэх боломжтой.</p> <p>Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой техникийн зөвлөгөө, дасан зохицох төлөвлөгөө боловсруулахад мэргэжлийн холбоод оролцож болно.</p>
10	татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх;	Үгүй	Тус хуулийн төслөөр аливаа татвар хураамж нэмж тогтоогоогүй.
11	тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх;	Тийм	"Уур амьсгалын өөрчлөлтийг даван туулах тухай" хуулийн төсөлд тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалт тусгагдаагүй.
12	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон	Үгүй	Хуулийн төсөлд хүний эрхийг шууд хязгаарласан зохицуулалт ороогүй.

	улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх;		
13	хуулийн төслийн зүйл, заалт жендерийн эрх тэгш байдлыг хангасан эсэх;	Тийм	Хуулийн төсөлд тусгайлан зохицуулалт тусгагдаагүй. Энэ асуудлыг Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хүрээнд зохицуулах боломжтой.
14	хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Үгүй	Хуулийн төсөлд тусгайлан зохицуулалт тусгагдаагүй бөгөөд энэ асуудлыг Өрсөлдөөний тухай хуулийн хүрээнд зохицуулах боломжтой.
15	хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Үгүй	Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгох заалт тусгагдаагүй.
16	хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.	Тийм	Тухайн хуулийг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг Эрүүгийн хууль, Төрийн албаны тухай хууль, Зөрчлийн тухай хуульд тусгасан.

ТАВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГӨХ

5.1. Үр дүнг баримтжуулах

Үнэлгээний арга зүй:

- Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхэд шаардлагатай мэдээлэл, тоо баримт, оролцогчдын санал, мэргэжлийн холбоодоос ирүүлсэн зөвлөмжийг цуглуулсан.
- Үнэлгээний үе шат бүрийн үйл ажиллагааг баримтжуулж, дүгнэлтэд ашигласан.

5.2. Үнэлгээний шалгуурын дүн шинжилгээ

Хүснэгт 5. Үнэлгээний хүснэгт

№	Шалгуур	Дүгнэлт
1.	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн сонгогдсон зохицуулалт нь хуулийн төслийн зорилго болон түүнийг боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлагад нийцсэн байна.
2.	Практикт хэрэгжих боломж	Хуулийн төслийн практикт хэрэгжих боломж өндөр бөгөөд хэрэгжүүлэх субъектуудын бүтэц, үүрэг хариуцлага, хүний нөөцийн чадавх, санхүүжилтийн тогтолцоо, мэдээллийн систем, хяналт, тайлагналын механизм зэрэг гол зохицуулалтуудыг нарийвчлан тодорхойлсон байна.
3	Ойлгомжтой байдал	Хуулийн төслийн бүх зүйл, заалтууд нь хамаарах этгээдүүдэд ойлгомжтой, нэг мөр ойлгогдохуйц байдлаар томъёологдсон байна. Хуулийн төслийг боловсруулагчийн зүгээс Хууль тогтоомжийн тухай хууль, “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-ыг баримтлан боловсруулсан байна.
4	Уялдаа холбоо	“Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ын 4.10-т заасан уялдаа холбоог шалгах хэрэгсэлд дурдагдсан шалгуурыг хангасан эсэхийг дараах байдлаар үнэлсэн. “Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг аргачлалд тусгасан хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх стандарт асуултуудад хариулах замаар уялдаа холбоог шалгахад тус шалгуурыг хангасан гэж дүгнэлээ.

5.3. ЗӨВЛӨМЖ

Хуулийн төсөлд уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг үндсэн зорилго, зорилтууд тусгагдсан байна. Төрийн байгууллагуудын хэрэгжүүлэх чиг үүргийг тодорхой болгосон ба цаашид Уур амьсгалын Үндэсний хороо, төрийн захиргааны төв байгууллага, нутгийн захиргааны хоорондын хамтын ажиллагааны механизмыг сайжруулан тусгахыг зөвлөж байна. Мөн хувийн хэвшлийн байгууллагуудын оролцоог хангах, хамтын ажиллагааг дэмжих урамшууллын тогтолцоог бий болгох шаардлагатай байна.